

**УСНЫ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН УСНЫ ТОО БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
БОЛД ОВОГТОЙ ЖАВХЛАНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ /Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 6.3, 9.2, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Зорилт 6.3, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Зорилт 1.3.1.2, 3.4.1.7, 3.4.2.4, 3.4.2.5, 3.4.2.7, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний Зорилт 1.11.3/							
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 1 ДҮГЭЭР ЗОРИЛТ: УСНЫ НӨӨЦИЙГ СУДАЛЖ ТОГТООХ, УСНЫ НӨӨЦ, ТҮҮНИЙ САВ ГАЗРЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ, ҮЕР УСНААС ХАМГААЛАХ, УСНЫ НӨӨЦИЙГ ХУРИМТЛУУЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЖ, АРВИЖУУЛАХ, УСНЫ НӨӨЦИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, УСНЫ НӨӨЦӨД ТУЛГУУРЛАСАН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЖ, ХЯНАЛТ ТАВИХ, УСНЫ САВ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ. /БОАЖ сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/49 дугаар тушаалаар батлагдсан Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн стратегийн зорилт 2.4.1/							
1.	Арга хэмжээ 1.1. Дундговь аймгийн Адаацаг сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох эрэл хайгуулын ажлыг зохион байгуулах, өгсөн ажлын даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих	Ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгаа хийсэн сумдын тоо	-	Дундговь аймгийн Адаацаг сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын тендер сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ажлыг эхлүүлсэн байна	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх ажлын даалгаврыг боловсруулж, 2025.05.14-ний өдөр батлуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж байна. Худалдан авах ажлыг нээлттэй сонгон шалгаруулах зарыг tender.gov.mn цахим хуудсаар 2025.05.21-ний өдөр нийтэлсэн. Тус тендер 2025.06.12-ны өдөр нээж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна.	01.01-06.06	100 90
2.	Арга хэмжээ 1.2. Сав газрын УННМТ-г батлагдсан аргачлалын дагуу боловсруулах ажлыг мэргэжил	Мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан УННМТ-ний тоо	-	2-оос доошгүй сав газрын УННМТ-г шинэчлэн боловсруулахад мэргэжил, аргазүйн	“Буйр нуур-Халх голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”, “Улз голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”, “Идэр голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”, “Дэлгэрмөрөн голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”-г Байгаль орчин, уур амьсгалын	01.01-06.06	100 80

	арга хангах	зүйгээр		зөвлөмж өгч ажиллана.	өөрчлөлтийн яамны дэргэдэх Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжүүлсэн. Туул голын сав газрын менежментийн төлөвлөгөөг Усны газрын Хатантуул танхимд хэлэлцүүлсэн. Гүйцэтгэгч байгууллага "Престиж инженеринг" ХХК болон бусад гэрээт оролцогчид танилцуулга хийсэн.		
3.	Арга хэмжээ 1.3. Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах урсцыг сайжруулах, ажлын II үе шат /Сүхбаатар/-ны ажлыг хэрэгжүүлэх /Нийт санхүүжилт 3,000 сая.төг. 2024 онд 1,500 сая.төг, 2025 онд 1,500 сая.төг/	Ганга нуурын тэжээгдлийн эх үүсвэрийг тогтоож, нуурын усны тогтвортой байдал, нуурын мандлын талбай, гүн багасах, бохирдохоос урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	Багц-1 50 хувь, Багц-2 40 хувь, Багц-3 60 хувь, Багц-4 20 хувь	Багц-1 60 хувь, Багц-2 60 хувь, Багц-3 70 хувь, Багц-4 50 хувь	Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах ажлын II үе шатны ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Усны газар, гүйцэтгэгчид 2025.03.28-ны өдөр Төрийн ордны хурлын танхимд 2025 онд хийж хэрэгжүүлэх ажил, төлөвлөгөө боловсруулан ажилласан. Тус ажлын үр дүнд: Багц-1: "Газрын доорх усны эх үүсвэрийг сэргээхэд хийж гүйцэтгэх ажил"-ын хүрээнд Баянбулгийн эхийг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэхээр төлөвлсөн. Геодезийн зураглалын ажлыг хэрэгжүүлж дууссан. Багц-2: "Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалахад хийж гүйцэтгэх ажил"-ын хүрээнд 2024 онд элсний нүүдлийг зогсоох зорилгоор ямар материал хийцлэл тохиромжтой эсэхэд мониторингийн зориулалтаар 1000 м² /1га/ талбайг сонгон 3 төрлийн материал /чулуу, торон, орон нутгийн унасан мод мөчир/-аар хийж гүйцэтгэсэн судалгааны үр дүнг нягтлах, баталгаажуулах, БНХАУ-ын мэргэжилтнүүдээс туршлага судлах, заавар зөвлөгөө авахаар Захиалагчийг төлөөлж Дарьганга БЦГ, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, "Престиж инженеринг" ХХК-ийн ажилтнууд БНХАУ-д 2025.05.04-05.11-ны өдрүүдэд газар дээр нь ажиллаж туршлага солилцсон. Одоогоор аль материалыг сонгох, төлөвлөх ажлыг зохион байгуулж байна. Багц-3: Хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, ойн төгөл байгуулах ажил"-ын хүрээнд нийтдээ 19,200 мод тарьж төлөвлөгөөт хэмжээндээ хүрсэн. 2024 онд суулгасан мод 80-90 хувийн ургалттай байгаа бөгөөд усалгаа хийх ажлыг тогтмол хийж байна. Явган зам, дуслын усалгааны систем, сандал, сүүдрэвч барих ажлыг хэрэгжүүлж байна. Багц-4: "Шувуу харах цамхаг байгуулах ажил"-ын хүрээнд ажлын төсөвт өртөг нэмэгдсэн тул нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг судалж байна. Мөн "Төсвийн хөрөнгө оруулалтын	01.01-06.06	90

					талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тогтоолын дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны хөрөнгө оруулалтад батлагдсан 2024 оны санхүүжилт болох 96,087,416.0 (ерэн зургаан сая наян долоон мянга дөрвөн зуун арван зургаан) төгрөгийг Төрийн сан дахь 100900013351 тоот Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан.		
4.	Арга хэмжээ 1.4. Улсын усны мэдээллийн санг зүгшрүүлэх, хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах	Улсын усны мэдээллийн санг сайжирсан байна.	www.infowater.mn цахим системийг бий болгосон	Улсын усны мэдээллийн санг www.infowater.mn цахим порталын мэдээ бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна	2025 оноос эхэлж www.infowater.mn цахим платформ-д усны тоо бүртгэлийн мэдээллүүдийг тогтмол оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Усны нөөц, ашиглалтын жилийн мэдээллийг боловсруулах аргачлал, гарын авлага боловсруулан аймаг нийслэлийн Байгаль орчны газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд үүний үр дүнд Байгаль орчны статистик мэдээллийн бүрдэл сайжирсан. 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр "Улсын усны мэдээллийн систем" /www.infowater.mn/ -ийг үйл ажиллагаандаа ашиглахтай холбоотой сургалтыг 21 сав газрын захиргаад, 22 аймаг нийслэлийн Байгаль орчны газрын албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.	01.01-06.06	100 70
5.	Арга хэмжээ 1.5. Улсын усны мэдээллийн санд eic.mn-д сав газрын захиргаадын мэдээллийг төвлөрүүлэх	Улсын усны тоо бүртгэлийн мэдээллийн бүрдэл	21	Улсын усны мэдээллийн санд өмнөх оны мэдээллүүдийг хянаж, зөрүүтэй тоо мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулсан байх,	Улсын усны мэдээллийн санд 2024 оны мэдээллүүдийг хянаж, зөрүүтэй тоо мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулсан бөгөөд иргэн аж ахуй нэгж байгууллагуудыг устай холбоотой мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. "Улсын усны мэдээллийн систем" /www.infowater.mn/ цахим платформыг www.eic.mn болон www.egazar.mn цахим платформуудтай холбох ажлыг дуусгасан бөгөөд Сав газрын захиргаадын нэвтрэх эрхийг нээж өгөн материал бүрдүүлэх, мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	01.01-06.06	100 50
6.	Арга хэмжээ 1.6. Аймаг нийслэлийн БОАЖГ-уудаас Байгаль орчны мэдээллийн санд БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу оруулсан мэдээллийг	БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу дүн 2023 оны дүн мэдээг авч нэгтгэсэн байна.	339	Аймаг нийслэлийн Байгаль орчны газраас БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд хянаж,	Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд оруулсан. Монгол орны усны тоо бүртгэлийн 2024 оны дүн мэдээгээр: - Нуур, тойром – 4584; - Гол, мөрөн – 7050; - Булаг, шанд – 14519;	01.01-06.06	100 80

	хяналт, мэргэжил аргазүйн зөвлөмж өгөх;			байгаль орчны мэдээллийн санд оруулсан байх,	- Рашаан – 622; - Усан сан, хөв цөөрөм – 310; Худаг – 75027 тоологдсон. Үүнээс Монгол Улсын хэмжээнд 2024 онд гол горхи 16, нуур тойром 105, булаг шанд 280, рашаан 6 буюу нийт 409 гадаргын ус сэргэсэн бол гол горхи 79, нуур тойром 123, булаг шанд 247, рашаан 7 буюу нийт 458 гадаргын ус хатаж ширгэсэн байна. Нийтдээ 21 аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудыг мэргэжил аргазүйгээр ханган ажиллаж байгаль орчны статистик мэдээллийг бүрдүүлсэн.		
7	Арга хэмжээ 1.7. Усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтийг хангаж, улсын усны төлөв байдлын тайланг гаргах	Усны төлөв байдлын тайлан	2021-2023	Улсын усны 2024 оны төлөв байдлыг боловсруулахад мэргэжил аргазүйгээр хангаж ажиллах,	“Монгол орны байгаль орчны 2021-2023 оны төлөв байдлын тайлан”-г хүлээн авч иргэд аж ахуй нэгж байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны төлөв байдлын тайланг боловсруулахаар сав газрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнүүд, Байгаль, орчны газруудын усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлан боловсруулах ажил үргэлжилж байна.	01.01-06.06	100 70
ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ Усны тухай хуулийн 7 дугаар зүйл, 16 ¹ - дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 4.5, 4.6, 4.10 дахь хэсэг Зорилт 2. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ”							
1.	Арга хэмжээ 2.1. Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргах;	Гаргасан дүгнэлтийн тоо	43	Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт 10-аас доошгүйг гаргасан байна.	“Усны тухай” хуулийн 16¹.4.10 дахь заалтыг үндэслэн 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасан 39 ААНБ-аас хүсэлт ирүүлснээс дүгнэлт гаргах боломжгүй 8 төсөлд холбогдох хариуг цахимаар хүргүүлж, 15 ААНБ-д дүгнэлт гаргасан. Үүнд: • Барилга, дэд бүтэц – 2 • Амралт, сувилал, аялал жуулчлал – 2 • Уул уурхай – 4 • Агуулах – 4 • Хөнгөн үйлдвэр – 3 Одоогоор 8 аж ахуй нэгж байгууллагын усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг судалж, 8 аж ахуй нэгжийн дүгнэлтийг материал дутуу тул засварт буцаасан.	01.01-06.06	100 80
2.	Арга хэмжээ 2.2. Иргэн, аж ахуй нэгж, мэргэжлийн байгууллагаас	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэ	53	Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 10-аас доошгүй албан	“Усны тухай” хуулийн 16 ¹ .4.5 дахь заалтыг үндэслэн 2023 оны эхний хагас жилийн байдлаар мэдээлэл гаргуулахаар хүсэлт гаргасан 55 төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийг холбогдох мэдээллээр хангаж ажилласан. Үүнд:	01.01-06.06	100

	ирсэн албан бичиг, хүсэлт, мэдээллээр ханган ажиллах, хариуг хуулийн хугацаанд нь гаргаж шийдвэрлэх;	н албан бичгийн тоо		бичиг, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн байна.	Эрчим хүчний яам, Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний статистикийн хороо, Шинэ хархарум хотын захиргаа, Нийслэлийн байгаль орчны газар, Алтайн Өвөр говийн сав газрын захиргаа, Хараа Ерөө голын сав газрын захиргаа, Ус сувгийн удирдах газар, Дорнод нийтийн аж ахуй, Эрдэнэт үйлдвэр, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Байгаль орчны судалгаа шинжилгээний төв, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж, Монголын мянганы сорилтын сан, "Баатар хангай" ХХК, "Карст" ХХК, "Хүрээ дэл майнинг" ХХК, "Эко Ургамал" ХХК, "Престиж инженеринг ХХК", "Арвайн үндэс" ХХК, "Маргад очирваань" ХХК, "Юргана индастри" ХХК, "Хадат ресорт" ХХК, "Ханлаб" ХХК, "Пролианс" ХХК, "Хан роял" ХХК, "Батпауер" ХХК, "Эрхэт инноваци" ХХК, "Пластик центр" ХХК, "Ситимент" ХХК, Монгол Улсын иргэн Ц.Халиун, Д.Адъяахүү		80.
--	--	---------------------	--	---	--	--	-----

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

Усны газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилт 5. Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар хүргэх

Зорилт 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ"

1	Арга хэмжээ 3.1. Усны тухай хууль болон бусад хууль эрх зүйн харилцааг хэрэгжүүлэх, хариуцсан асуудлын хүрээнд БОАЖЯ, нийслэл болон холбогдох бусад газруудаас байгуулах ажлын хэсэгт орж ажиллах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах.	Томилолтоор ажилласан тайлан Ажлын хэсэгт хүргүүлсэн мэдээлэл	4	Хариуцсан асуудлын хүрээнд БОАЖЯ болон холбогдох бусад байгууллагуудаас байгуулах ажлын хэсэгт ажиллаж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хамтран ажиллана.	- 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны албан хаагчдад газрын доорх усны эрэл хайгуулын ажлаар хэрхэн хяналт тавьж ажиллах, холбогдох мэдээллүүдэд хэрхэн анализ хийх тухай сургалт явуулсан. - Усны газрын даргын 2025 оны А/49 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 14-16-ний өдрүүдэд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн Эртний нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулах, хотын төлөвлөлтийн үзэл баримтлалын хүрээнд ажлын дагуу "Өгий нуурыг сэргээх" сэдвээр илтгэл хэлэлцүүлж төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгжүүдэд устай холбоотой мэдээлэл өгч ажилласан. - Монгол Улсын Их Хурлын гишүүд болон Засгийн газрын албаны төлөөлөгчид 2025 оны 05 дугаар сарын 17-26-ний өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Колорадо мужид болох	01.01-06.06	100 80
---	---	--	---	--	---	-------------	-----------

					туршлага судлах арга хэмжээнд оролцож Колорадо болон Миссиссиппи голын сав газарт хэрэгжиж буй "Цэнгэг ус" хамгааллын төслийн дэвшилтэт арга барил, усны нөөцийн менежментийг бодит туршлага болгоход тулгарч буй сорилтын талаар мэдлэг ойлголт авах, цэнгэг усны экосистемийг хамгаалахад усны менежментийг хэрэгжүүлэх замаар усны салбарын оролцогч талуудтай хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах арга туршлагыг олж авах, АНУ-ын газар нутаг, усыг хамгаалах олон янзын аргачлал, менежментийн боломжууд, мөн хамгаалалттай бүс нутгийн захиргаадын оролцоо, хамтын ажиллагаа, хамгааллын үйл ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай танилцсан.		
2	Арга хэмжээ 3.2. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	2	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулж, хэрэгжүүлэх, биелэлтийг хагас жилээр тайлагнасан байна.	- ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, загварын дагуу 2025 оны төлөвлөгөө боловсруулж, хэлтсийн даргаар батлуулсан. - Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг гаргасан.	01.01-06.06	100 

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	

**"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН
МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

1.	Мэргэшүүлэх сургалтад хамрагдах;	Гэрчилгээний тоо	1	Төрийн албан хаагчдад зориулсан сургалтад хамрагдаж, холбогдох хууль, дүрэм журмыг судалсан байна.	Төрийн албан хаагчдад зориулсан холбогдох хууль, дүрэм журмыг судалж байна	01.01-06.06	100 (✓)
2.	Хандлага, ёс зүй, ур чадвараа дээшлүүлэх	Сургалтын тоо	1	Байгууллагаас зохион байгуулах дотоодын сургалтуудад тухай бүр хамрагдаж, ажлын үр дүн, бүтээмжийг сайжруулах, ур чадвар эзэмшинэ.	Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2005 стандартын сургалтад тухай бүр хамрагдсан. АТГ-с хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлэг анхаарах асуудал сургалтад оролцсон. 2025.01.11	01.01-06.06	100 90

ТАЙЛАН ГАРГАСАН:

Усны тоо бүртгэл, мэдээллийн сан
хариуцсан мэргэжилтэн

 /Б.Жавхлан/

2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр